

ШАШНЫ ТУХАЙ СЭДВИЙГ ФИЛОСОФИЙН ҮҮДНЭЭС ХЭРХЭН АВЧ ҮЗВЭЛ ЗОХИСТОЙН АСУУДЛААС

Ц. Гомбосүрэн - МУИС. НШУС. Философийн тэнхим

Б. Дагзмаа - МУИС. НШУС. Философийн тэнхим

Түлхүүр үгс: Шашны тухай Ф. Энгельсийн тодорхойлолт. Шашин дахь нийгмийн үйл (функц)- ийг К. Маркс томъёолсонд үнэлгээ өгөх нь. Шашны туршлага. Шашны миф. Шашин, мэдлэгийн зарим (шинжлэх ухаан, философи гэх мэт) гол төрөл хоёрын харьцаа.

Товч агуулга: Энэ өгүүллийн зорилго нь 1990-ээд оноос өмнөх олон арван жилд манайд шашныг үнэлэхдээ монист аргазүйд үндэслэж байсныг хэрхэн даван туулах талаарх онолын байр сууриа зохиогчид илэрхийлэхэд чиглэв. Ийм зорилтын хэрэгжилт нь тухайн сэдвийн асуудлуудаар ажил, мэргэжил ижил ба ойролцоо хүмүүстэй санал солилцох нэг хэлбэр болно хэмээн найдаж байна.

Бид энэ өгүүлэлдээ манай философийн судалгаа, сурталчилгаа, сургалтын ажилд нилээд тусгагдаж байгаа шашны тухай философийн дараах зарим ойлголт, үндэслэлийг онцлон авч үзэх юм.

Шашны тухай ойлголтын тодорхойлолтын асуудал. Шашин гэж юу болохыг социализм байгуулж байсан орнуудын, түүний дотор монголын онолчид албан ёсны үзэл сурталд тохируулан тодорхойлохдоо: “аливаа шашин бол хүмүүсийн өдөр тутмын амьдралд ноёлон байгаа гадаад хүчин хүмүүсийн тархинд хувьсан урвуу туссан явдал, газар дэлхийн хүчин хурмастын хүчин болж туссанаас өөр юу ч биш билээ”¹ гэж Ф.Энгельс томъёолсныг арга зүйн үндэс болгож ирсэн юм. Тийнхүү шашинд бүхэлд нь сөрөг ханддаг үнэлгээг 70 жилийн турш Монголын нийгэм, төрийг удирдаж ирсэн Монгол Ардын Хувьсгалт Нам бодлого, үйл ажиллагаандаа чанд баримталж ирсэн түүх бол зөвхөн марксист-ленинист сургаалыг ганц үнэн шинжлэх ухаанч гэж баримталж ирсний илэрхийлэл мөний хамт дэлхий дахинаа шинэ үеийн түүх эхэлсэн хугацаанаас хойшхи тэргүүний хөгжилтэй орнууд шашны хуваарьгүй ноёрхлыг үзэл санааны хүрээ, практик амьдрал аль алиндаа эвдсэний хувьсгалжуулагч нөлөө байлаа.

Дурьдан буй үеийн Монголын нөхцөлд шашны эсрэг суртал нэвтрүүлгийн үзэл санааны удирдамж нь марксизм-ленинизмийг үндэслэгчдийн холбогдох онол ба үзэл, түүний дотор “шашин бол ард түмнийг мунхруулагч хар тамхи мөн” гэдэг К. Марксын томъёолол болж ирсэн юм.

Харин 1990-ээд оноос хойш шашин гэж юу болох тухай асуудлыг олон ургальч зарчмын үүднээс авч үзэх бололцоо манайд бий болсон билээ. Жишээ нь: монголын философичдын заримынх нь тайлбараар шашны үүсэл ба тодорхой өөрчлөгдөлт бол нийгмийн амьдралын аливаа хүрээ, соёлын бүх төрөлтэй холбогдож, нэг талаар тэдгээрийн тухай онолын заримд үзэл санааны нь үндэс, нөгөөтэйгүүр тодорхой нөхцөлд тэдгээрийн үр дагавар болж байдаг. Эл тайлбарынхаа үүднээс шашны ийм (ертөнцийг үзэх үзэл илэрхийлдэг, ёс

¹Ф. Энгельс. Дюрингийн эсрэг, УБ., 1981. 352 дахь тал

суртахууны ач холбогдолтой, гэгээрэлд хүргэдэг, аврагдах сүсэг төрүүлдэг, төр улсын нийт амьдралд үзүүлдэг нөлөө гэх мэт) олон тал ба олон үйлийн аль нэгийг юм уу, зарим хэдийг нь онцлох үндсэн дээр, эсвэл аль нэг шашны онцлогийг чухалчлах замаар ер нь шашин гэж юу болох тухай өөр өөр тодорхойлолтыг судлаачид томъёолдог гэсэн дүгнэлтийг тэд хийж байна. Улмаар тэдгээр философич янз бүрийн шашинд нийтлэг нэг чухал талыг нь онцолсон интеграль тодорхойлолт томъёолох зорилт тавьж ирлээ. Тэгээд тэд: шашин бол хүн өөрийгөө үнэмлэхүй аврагч хэмээн сүсэглэж буй ер бусын, далдын, төгөлдөр хүчийг юу гэж ухаардгаа ерийн ухамсрын ба онолын түвшинд илэрхийлдэг итгэл үнэмшил, бишрэл, сүсэг зэргийн цогц мөн гэсэн тодорхойлолт илэрхийлжээ.

Аврагч чанад хүчний тухай ойлголт. Бидний төсөөлж байгаагаар аливаа шашин дахь хамгийн гол чанад ойлголт (трансцендентали) бол "аврагч" гэдэг ойлголт мөн. Бодгаль хүн, хүмүүсийн янз бүрийн нийтлэг болбоос байгаль, нийгмийн тодорхой хүчин зүйлийг аль нэг шашинтай холбохгүйгээр дээд аврагчаа хэмээн шүтдэг тохиолдолтой байдаг бол ямар ч шашны сүсэгтний хувьд жинхэнэ аврагч бол ер бусын, төгөлдөр, далдлаг хүч байдаг. Чухам ямар төгөлдөр хүч вэ? гэдгийг шашин бүхэн өөр өөрийнхөөрөө тайлбарладаг. Жишээ нь, буддын шашны үүднээс үнэмлэхүй аврагч бол Бурхан багш мөн. Тэр бол хутагт үнэний цаад хязгаарт хүрсэн гэгээнтэн учир бодгаль хүнд төдийгүй нийт хүн төрөлхтөнд зовлонгоос ангижрах арга замыг зааж өгсөн тийм аврагч мөн. Гэхдээ Бурхан багш бол гэгээрсэн багш хүн төдий биш, харин эхийн хэвлийд бүрэлдсэнээсээ авахуулаад энэ дэлхийд мэндэлсэн, хамаг амьтны тусын тулд үйлдсэн бүхэн нь ер бус тийм Аврагч мөн гэдэг шидэт домгийн утгатай мэдээ элбэг байдаг билээ.

Христос шашны үүднээс үнэмлэхүй аврагч бол англиар "God", оросоор "Бог" гэж нэрлэдэг Бүтээгч мөн. Харин энэ Бүтээгчийн нэрийг монгол хэлэнд сүүлийн 20-иод жилд "Ертөнцийн эзэн", "Ертөнцийн Мөнх эзэн", "Бурхан", "Бурхан тэнгэр", "Эзэн тэнгэр", "Эрхэт тэнгэр" гэх мэтээр олон янзаар орчуулж иржээ. Энэ нь уншигч, сонсогч нарыг утга зүй, танин мэдэхүйн төөрөгдөлд оруулж, улмаар хүн амын дунд суртал ухуулгын шударга биш үр дагавар бий болгох эрсдэлтэй байдаг. Тухайлбал манайд социализмын жилүүдэд христос шашны шүтээн-Бүтээгчийн нэрийг "бурхан" гэж орчуулдаг байсан нь хоёр өөр шашны ялгаатай чанад ойлголтуудын агуулгыг адил юм шиг ойлгодог болоход суралцагч, өргөн олон уншигч нарыг хүргэж иржээ. Харин үзэл санааны олон ургальч зарчим манай оюуны амьдралд нэвтэрсэн эдүгээгийн нөхцөлд христос шашны дээд шүтээний нэрийг "бурхан" гэж орчуулан хэрэглэх нь нэг бол зарим хүний хуучин сэтгэлийнх нь илрэл, нэг бол тийм хуучин сэтгэлгээ олон хүнд инерциэрээ, хадгалагдсаар, буйг, христос шашны талын зарим сурталч нар өөрсөддөө тохируулан зориуд ашигладаг байдал мөн байх үндэстэй.

Зарим судлаачдын дурддагаар бол христос шашны "бог (god)" гэдэг ойлголтыг монголчууд Ганжуур, Данжуурын орчуулгадаа "Эрхэт тэнгэр", "Чадагч

тэнгэр” хэмээн хөрвүүлсэн ажээ. Уг ойлголтын нэрийн орчуулгыг манайхан жигдлэхдээ эл уламжлалыг дагавал тохиромжтой санагдаж байна.

Дэлхий дахинаа арабын гол шашныг илэрхийлэхдээ англиар “Islamic” хэмээн тодотгож, орос хэлэнд түүнийг дагадаг билээ. Энэ шашныг монгол хэлнээ “ислам шашин” хэмээн орчуулдаг. Гэтэл зарим хүн “лалын шашин”, “лалын ертөнц” гэх мэтээр бичиж, ярьдаг. Угтаа буддистууд “лал”, “лалын” гэдэг үг хэрэглэхдээ ад үзсэн, дорд үзсэн утга илэрхийлдэг байсан бололтой бөгөөд үүнийг бид харгалзддаг байх ёстой.

“Шашин бол ард түмнийг мунхруулагч хар тамхи мөн” гэдгийг хэрхэн ойлгох ёстой вэ? Манайд нийгмийн амьдралын оюуны хүрээнд марксизм-ленинизм ганцаараа ноёрхож байсан жилүүдэд К. Марксын эл томъёоллыг гносеологийн хувьд шашны тухай Ф.Энгельсээс бид дээр иш татсан тодорхойлолт дагуу, нийгмийн үнэлэмжийн хувьд хүн төрөлхтний оюуны соёлын эртний бөгөөд нэн чухал энэ төрлийг бүхэлд нь харлуулан муучлах зорилгод нийцүүлэн тайлбарладаг байв. Угтаа шашныг хар тамхины хорт нөлөөтэй адил үйл бүхийгээр ойлгох байдал зөвхөн мухар сүсэгтнүүдэд, шашны үндэслэлүүдийг зөвхөн ерийн ухамсрын төвшинд махчлан ойлгодог нөхцөлд хүчинтэй гэж ойлгох ёстой бололтой. Харин гэгээнтнүүдэд төдийгүй сүсэгтнүүдийн үлэмж хэсэгт К. Марксын тэр томъёоллыг хүчинтэй гэж үзэх үндэсгүй байдаг. Тэдний хувьд шашны сургаал дахь мифологи (шидэт домог байдалт) мэдээнүүд бол далд (эзотерик) мэдлэг, өөрөөр хэлбэл далд ертөнц, манай хүн төрөлхтний түүхээс өмнийн буюу сөнөсөн иргэншлүүдийн хүмүүсийн намтар зэргийг бэлгэдсэн гэгээн мэдээнүүд юм. “Хүн бол бэлгэдэл бүтээгч амьтан мөн” гэдэг Серен Кьеркегорын томъёолол аливаа хүн бүрт хүчинтэй байж чадах байлаа ч шашин дахь мифологи мэдээнүүд аваас зөвхөн гэгээнтнүүд тайлбарлаж чадах тийм бэлгэдсэн мэдээнүүд мөн гэж ойлговол зөв бололтой.

Хэрвээ шашны мифологи мэдээнүүдийн утгыг зөв тайлж, ямар бэлгэдэл илэрхийлж буйг нь ухаарч чадвал тэдгээр нь хүн төрөлхтөн ертөнцийн уг чанарыг ухаарахад туслах, хүн төрөлхтнийг гэгээрүүлэх, сэтгэл ба үйлдлийг нь ариусгах, товчоор хэлбэл хүн шиг хүн явцгаахад онцгой нөлөөлөх ач холбогдолтой юм.

Гэгээнтэн гэж хэн бэ? “Гэгээнтэн” гэдэг нэр томъёог зөвхөн шашны туршлагыг бүтээгч нарт биш, ер нь оккульт, эзотерик зэрэг далд чанад ертөнцийг барин мэдэж, нээн тайлбарласан мэдлэг бүтээгч нарт оноон хэрэглэдэг ажээ. Онолын янз бүрийн төрлийн мэдлэг, түүний дотор шинжлэх ухаан үүсээгүй байсан нөхцөлд Фалес, Пифагор, Кун-з, Платон зэрэг парафилозофийг (бараг философи) өөр өөрийнхөөрөө бүтээгч нарын ертөнцийг үзэх жич жич үзэл бол тэдний сэтгэхүйн бүтээлийн үр дүн төдий биш, хамгийн гол нь тэдний гэгээн мэдрэмж, гэгээн мэдлэгийн илэрхийлэл мөн гэсэн дүгнэлтийг олон гэгээнтэн, тэдний дотор Дорно, Өрнийн шашин,

философийг нэвтэрхий судалсан оросын зохиогч, дэлхий дахины теософи хөдөлгөөнийг үндэслэгч Е. П. Блаватская (1831-1891) хийсэн байдаг.²

Шашны мифүүдийн утгыг төгс ойлгох боломжтой юу? Ийм асуултанд шашны сургаалд нэвтэрсэн гэгээнтнүүд л зөв хариулт итгэлтэй өгч чадах болов уу. Харин бид мэтийн оюун ухаандаа голлон түшдэг хүмүүсийн нэлээд нь: шашны мифүүдийн утгыг зөвхөн үнэлэмжийн үүднээс тайлбарлах бололцоотой гэсэн дүгнэлт хийх үндэстэй. Ийм дүгнэлтээ зөвтгөн дурдахад Библийн жич жич мэдээнд орчин үеийн онолчид өөр өөр герменевтик тайлбар хийдэг билээ.

Шашны туршлага. Шашны туршлага бол бурхан тэнгэрлэг бодит байдалтай хүн харьцдаг янз бүрийн харилцааны цогц мөн. Энэ туршлагын маш чухал бүрдэл бол сүсэг мөн. Сүсэг бол бодгаль хүн ба хамтлаг хүмүүс шүтээндээ үнэнч буй харьцаа мөн.

Догдлон мэдрэхүй бол сүсэгтэй нягт уялддаг шашны туршлагын элемент мөн. Түүний хэд хэдэн хэв маяг байдаг. Үүнд: Дээд шүтээнээ дээд аврагч гэж сүсэглэн, Түүндээ сөгддөг мэдрэмж, авралт ба аюулт аливаа шидэт хүчний өмнө өөрийгөө юу ч биш гэж айн бэмбэгнэдэг мэдрэмж гэх мэт юм. Тийнхүү шашны догдлон мэдрэхүй бол хүний сэтгэлийг тайтгаруулах, найдвар төрүүлэх, эсвэл айн сүрдэх зэрэг янз бүрийн төлөвд оруулдаг үйлчилгээтэй байдаг.

Оюун ухаан, хэл, бишрэл гурвын харилцан уялдаа бол шашны туршлагын нэн чухал бүрдлүүд бас мөн. Шашны харилцаа бодгаль хүний хувийн сүсгээс халихлаараа оюун ухааныг шаарддаг. Энэ нь бас өвөрмөц хэлийг шаарддаг. Үүнд, шашны туршлага дахь оюун ухаан аваас бурхан тэнгэрийг нотлох логик талыг авч үзэж, шашны үндэслэлүүд уялдан авцалддаг гэж нотлох зорилго тавьдаг. Энэ зорилгоо хэлний тусламжтай хэрэгжүүлдэг. Уг хэл нь нэг талаар шашинлаг сэтгэлийн илэрхийлэл, нөгөө талаар тийм сэтгэлийг төрүүлэн бэхжүүлэгч хэрэгсэл болж өгдөг. Шашны хэл бол эх хэлний хэвшмэл өвөрмөц илэрхийлэл, хэлц үг, бас янз бүрийн бэлгэдэл, урлаг зэрэг олон төрөл бүхий байдаг. Ийм хэлээр илэрдэг мэдлэгийг шашны тухай философид “бишрэл” гэж нэрлэдэг. Тийнхүү шашны тухай орчин үеийн философид “сүсэг”, “бишрэл” хоёрын ялгааг тод заадаг.

Шашны туршлагын бүрдлүүдийг авч үзэхэд гарч буй орчин үеийн нэн адармаатай нэг философи категори бол “мистицизм” гэдэг ихээхэн гүн агуулгатай бөгөөд багтаамж ихтэй ойлголт байдаг. Мистицизмийн тайлбар ёсоор физик ертөнцөөс, түүний орон зай ба цаг хугацаанаас үл хамаармалаар, хүн төрөлхтний оюун ухааны ба практик үйлдлийн хязгаараас гадуур чанад, нууц хүчнүүд оршиж, тэдгээр нь хүн төрөлхтний амьдралд (бидэнд мэдэгдэх ба үл мэдэгдэх аль нэг байдлаар) нөлөөлж байдаг. Тийм далд ертөнцийн хүчүүдийг хүн төрөлхтний танин мэдэхүйн эмпирик ба логик янз бүрийн аргаар биш, харин увьдсын мэдрэмж, оюун ухаанаас дээгүүрх, гэгээрлээр, нээдэг, Мистицизмийн үндсэн хоёр төрөл байдаг нь оккультизм, эзотеризм хоёр мөн.

²См об этом напр.в кн: Е.П. Блаватская, Тайная доктрина. Том 1, М.-Харьков, 2004.

Агностицизм. Энэ нэр томъёог анх 1869 онд английн байгалийн шинжээч Томас Хенри Хексли хэрэглэсэн аж. Гол утга нь: хүн ёс суртахуунлаг биш байна гэдгийг би үгүйсгэж ч, нотолж ч чадахгүй байж болдог гэсэн санаа ажээ. Д.Хьюм, И.Кант нарыг агностицизмын төлөөлөгчид хэмээн Ф.Энгельс зарлахдаа тэр хоёр философич ертөнцийг танин мэдэж болохыг үгүйсгэдэг мэт санааг тэрээр илэрхийлдэг. Угтаа энэ хоёр философич ертөнцийг танин мэдэхийг үгүйсгэгч нар биш, харин танин мэдэхүй бол хязгаарлагдмал бөгөөд цаашаа үргэлжлэн гүнзгийрэх хандлагатай гэсэн санааг өөр өөрийн онол, арга зүйн онцлогийн үүднээс илэрхийлсэн байдаг. Иймээс тэднийг Ф.Энгельсийн тайлбарласан утгаар агностикчид гэж болохгүй юм.

Харин шашны янз бүрийн онолд “агностицизм” гэдэг нэр томъёог хоёр үндсэн утгаар ашигладаг. Үүнд: нэгдүгээрт; тэдгээр онол дахь агностицизм бол Бурхан тэнгэр байдаг эсэхийн алиныг нь ч үндэслэж чадах хангалттай нотолгоо байдаггүй гэдэг үзлийн нэр болж; хоёрдугаарт, оюун ухааны, түүний дотор шинжлэх ухааны мэдлэг хичнээн гүн, хүмүүсийн өдөр тутмын амьдрал, нийгмийн практикт ихээхэн ашиг өгдөг байлаа ч ертөнцийг яг байгаагаар нь танин мэдэж чаддаггүй тул мөн энэхүү (шинжлэх ухааны) мэдлэгт оноосон нэр томъёо болж тус тус ашиглагддаг.

Шашин ба шинжлэх ухаан. Орчин үеийн хүн төрөлхтний амьдралд шинжлэх ухааны ач холбогдол хэлбэрэлтгүй өссөөр байхад шашных нь нөлөө янз бүрийн улс орны амьдралд өөр өөр байж, ерөнхий хандлагаараа буурч байна. Гэхдээ эндээс шашин, шинжлэх ухаан хоёрын ийм харьцаа нь хүн төрөлхтний оюуны амьдралын дэвшлийн илэрхийлэл гэсэн дүгнэлт хийвэл дор хаяж маргаан төрүүлэхээр юм. Энэ нь шинжлэх ухааны хөгжил хүн төрөлхтний өнөө ба ирээдүйд дандаа дэвшил авчирсан уу? гэдэг асуудалд ямар хариулт өгөхтэй уялдах дүгнэлт мөн.

Хүн төрөлхтний өнөө ба ирээдүйн амьдралд шашин, шинжлэх ухаан хоёрын тус тусын гүйцэтгэл ямар байх вэ? гэдэгт хариулт өгөх нь оюуны соёлын энэ хоёр төрлийн нийтлэг ба ялгааг тодруулахтай гарцаагүй холбоотой гэж үзэж байна.

Шашин, шинжлэх ухаан хоёрт олон нийтлэг шинж байдгаас зарим голыг нь дурдъя. Үүнд: хүн төрөлхтний амьдралын сайн сайхны төлөө гэсэн зорилго тавьдаг; гэгээрүүлэх үйл бүхий байдаг; төр, улсын үйл хэрэгт идэвхтэй нөлөөлдөг; аль алины нь хүсэл эрмэлзэл эзэрхэхийн төлөө, тодруулан хэлбэл бүхнийг өөрийнхөө мэдлэгээр зохион байгуулах, удирдахын төлөө байдаг гэх мэт юм.

Үүний зэрэгцээ олон чухал ялгаа тэдгээрт байдаг. Тухайлбал: шашны үүсэл хүй нэгдлийн нийгэмд байсан бол шинжлэх ухааны үүсэл төрт нийгмүүдэд хамаардаг; шашин нь сүсэг, бишрэл хоёрт үндэслэдэг бол шинжлэх ухаан нь үнэн гэж үзэж буй мэдлэгт үндэслэдэг; онтологийн үүднээс шашин нь эзотеризмд, харин шинжлэх ухаан нь натурализм, техницизм, технологизмд үндэслэдэг; шинжлэх ухааны салбарууд өөр өөрийн онцлогийн үүднээс эмпирик

ба логик янз бүрийн аргуудаас сонгон ашиглаж байдаг. Харин шашин аваас бишрэлийн мэдлэг бий болгох тогтолцоот аргатай байдаггүй.

Шашин нь өөрийнхөө номлолын агуулгад харшилж буй шинжлэх ухааны нээлт, онолуудыг гол нь дээд нээгдлийг уран сайхны аргуудтай хослуулан ашиглах үндсэн дээр няцаах чармайлт гаргаж, харин шинжлэх ухаан нь өөртөө харш шашны үндэслэлүүдийг гол нь эмпирик аргуудаар няцааж байдаг. Ингэхдээ логик аргууд бас ашигладаг; шашин нь ерийн ухамсрын болон онолын аль аль төвшин дэх мэдлэг байдлаар оршдог ахул шинжлэх ухаан ямагт онолын төвшинд оршдог; шашин болбоос нийгмийн цогц тогтолцооны тогтворт, уламжлалт шинжийг илэрхийлж, харин шинжлэх ухаан энэ тогтолцооны өөрчлөгдөмтгий талтай уялддаг гэх мэт болно.

Гэхдээ шашны суурь зарчмууд үл өөрчлөгддөг тухай яриа аваас дэлхийн шашнууд үүссэнээсээ хойш өөрчлөгдөөгүй гэсэн үг биш билээ. Үүнд, тэдгээр шашин агуулгаа өөрчилдөггүй ч гэсэн хүн төрөлхтний танин мэдэхүйн, ялангуяа шинжлэх ухааны ойлголтуудад хандах хандлагаа олонтой өөрчилж ирсэн байна.

Шашин ба философи. Шашин, философи хоёрын харьцааны ээдрээт түүхийг хөндөлгүйгээр зөвхөн орчин үеийнх нь зарим гол илрэлийг энд дурдъя.

Шашин, зарим философи хоёрын сүлбээнд чухал үнэлэмж бүхий онцлог цөөнгүй байдаг. Тухайлбал: Монголын эдүгээгийн зарим судлаачдын бичдэгээр бол буддын гүн ухааны ("философийн" гэсэн утгаар эл нэр томъёог ойлгож байна) баримтлалууд Бурхан багшийн сургаалд засвар хийдэггүй, харин уг сургаалыг зөвхөн хамгаалан бататгах үйл бүхий байдаг бололтой. Гэтэл бусад зарим том шашны философи (religious philosophy) сургаалууд шашнаа бишрэлийн үүднээс бол хамгаалдгийн зэрэгцээ онолын хувьд түүнийхээ категориудыг (христос шашны онолын нэр томъёогоор илэрхийлбэл трансценденталиинуудыг) агуулгын хувьд засварт оруулж, шинэ санаа бүхий болгож, улмаар чухал чухал категори нэмэн боловсруулж байдаг. Тиймээс христос шашны философийн нэлээд эрс үзэлт төлөөлөгчид нь өөрийнхөө шашны сүм хийдийн эрх баригчдаас зэмлэл, шийтгэл амсах тохиолдол гарч иржээ.

Эдүгээгийн нөхцөлд голлон холбогдуулж хэлэхэд шашны философи сургаалууд бүхэлдээ үнэлэмжийн үр дүн байдаг. Гэтэл шашны тухай философи (Philosophy of religion)-ийн чиглэлүүд аваас үнэлэмжийн талтайн сацуу танин мэдэхүйн чухал талтай байж, тэр нь улмаар зарим нөхцөлд шинжлэх ухааны төвшинд илэрдэг. Учир нь гэвэл шашны тухай философийн зарим төлөөлөгч янз бүрийн шашныг харьцуулан үзэж, тухайн судлагдахуун нь тэдгээр шашны нийтлэг ба ялгаатай зүйлсийг илрүүлэх үйл ажиллагаа явуулдаг. Тийнхүү аль нэг шашныг бусдаас нь эрхэмлэж биш, харин, тэдгээрт, судалгааны, төвч байрнаас ханддаг байдал зөвхөн үнэлэмжийн биш, бас танин мэдэхүйн (эцсийн эцэст шинжлэх ухааны) үр дүн гаргадаг. Зарим философи шашныг судалгааныхаа гол объект болгодоггүй ч гэсэн чухал чухал ойлголт, асуудлаа шашны үзлийн үүднээс тайлбарладаг. Ийм байдал ялангуяа экзистенциализм дахь шашны жигүүрт тод илэрдэг.

Орчин үеийн философийн зарим чиглэл шашныг хамгаалдаг, шашнаас хамгаалалт авдаг онцлогуудаас жишээ болгон дурдахад ийм байна.

Гэтэл бас олон тооны философи чиглэл шашинд шүүмжлэлтэй хандаж, тэгээд бас тэдний ийм байр суурь нь бие биеийнхээсээ тодорхой ялгаатай байдаг. Тухайлбал; Фейербахын материализм, диалектик материализм, Ф. Ницшегийн философи, экзистенциализмын атеист жигүүр, З. Фрейдийн психоаналитик философи, бүр эдүгээгийн онолч болох сэр Реймонд Ферт шашныг гуманист байр сууринаас тайлбарласан зэрэгт атеизмын өвөрмөц өвөрмөц хэлбэрийг боловсруулжээ.

Шашны трансцендентализм бол сонгодог онтологийн нэг хэв маяг мөн гэж үзэх шаардлага. ХҮIII зууны Францын материализмын зарим төлөөлөгч: философи бол онтологийн хувьд материализм, идеализм гэсэн хоёр лагерьт хуваагддаг хэмээн үзэж түүнийг диалектик материализмын төлөөлөгчид үндэслэн нотлох үйл ажиллагаа явуулж ирсэн билээ. Ийм ангиллыг зөвтгөхөд чиглэсэн тэдний тайлбарын бүх дутагдлыг авч үзэх зорилт бид энд тавихгүй болно. Харин энд хоёр зүйлийг л онцлон дурдах зорилт бид тавьж байна. Үүнд: нэгдүгээрт, ХҮIII зууны францын материализмын үед философийн зөвхөн сонгодог (уламжлалт) хэв маяг байсан бол XIX зууны дунд үеэс хойш сонгодог биш (уламжлалт биш) философийн түрүү чиглэлүүд үүсэн, улмаар тэдгээр нь сонгодог онтологийн агуулгыг үгүйсгэж байв. Тэд тийм үгүйсгэлээ зөвтгөх олон ухаалаг үндэслэл томъёолсон ч гэсэн сонгодог онтологийг ор тас үгүйсгэсэн байр суурь нь нэгэн төрөл туйлшрал байв. Үүнийг XX зуунаас хойшхи философийн амьдрал улам тод гэрчилж иржээ. Хоёрдугаарт, сонгодог онтологийн төлөөлөгчид өөрсдийн сургаалыг танин мэдэхүй мөн, үүнд: онолын төвшиндөө шинжлэх ухаан мөн гэж үзсэн нь тэдний нэг ноцтой дутагдал байсан гэдэг дүгнэлтийг бид баримталж байна. Энэ онтологийн төлөөлөгчид ертөнц гэж юу болох тухай танин мэдэхүйн, түүний дотор шинжлэх ухааны зорилт дэвшүүлдэг байсан ч эцсийн үр дүн, дүгнэлт нь үнэлэмжийн утгатай байв. Тэгээд тэд ертөнцийн тухай материалист, идеалист, шашны философийн зэрэг өөр өөр чиглэлийн үнэлэмжийн онол боловсруулж иржээ.

Сонгодог философийг бүтээгч зарим онолч болбоос шашны философийг объектив идеализмд багтаан ирснийг буруу гэж бид үзэж байгаа юм. Тэгээд бид шашны философийн янз бүрийн чиглэлийн онтологид нийтэд нь "шашны трансцендентализм" гэдэг болзмол нэр оноон, сургалтын ба судалгааны ажилдаа ашиглаж ирэв.³

³Энэ нэр томъёог ашигласан нэг бүтээлийн нэр дурдахад: Бунийхны Ц. Гомбосүрэн. Философи. Сурах бичиг. УБ., 2008

Сонгодог онтологид шашны трансцендентализм бие даасан нэг хэв маяг болж байдаг гэж бид үзэхдээ нэн түрүүнд дараах үндэслэгээнүүдийг гаргаж байна. Үүнд: нэгдүгээрт, объектив идеализмд шашны эзотерик мэдлэгийн нөлөө, түүний тодорхой элементүүд шингэсэн байдгийг бид үгүйсгэхгүй байна. Гэхдээ Платон, Гегель хэн нь ч гэсэн өөр өөрийн идеализмыг хүний оюун ухаанаас, шинжлэх ухаанаас дээш хэтийдсэн (трансцендент) мэдлэгэнд үндэслэж биш, харин үндсэндээ рационализмын үүднээс боловсруулсан билээ. Гэтэл шашны философи чиглэлүүд рационализмыг ашигладаг талтай ч бүхэлдээ бол оккультизм, эзотеризм зэрэг мистик үзэлд үндэслэдэг байна. Хоёрдугаарт, Гегель зэрэг идеализмын сонгодог төлөөлөгч нар рационализмыг баримталж, философи сургаалаа шинжлэх ухааны онол хэмээн ойлгож, тийнхүү шинжлэх ухааныг мэдлэгийн бусад төрлөөс дээгүүр тавьж байв. Гэтэл шашны философийн олон чиглэл шинжлэх ухааны ач холбогдлыг даруухан үнэлсэн юм. Тэр үнэлгээгээр бол мэдлэгийн шатлалын дээд төвшинд нь шашны онол (теологи), доод суурь нь шинжлэх ухаан, энэ хоёрын дундах шат нь философи (гэхдээ аливаа философи биш, харин шашны философи өөрөө гэдгийг нь мартаж болохгүй) мөн.

Энэ мэтээр объектив идеализм, шашны трансцендентализм хоёрын ялгааг илтгэдэг үндэслэгээнүүд олдож байдаг.

* * *

Философийн сургалт, судалгаанд шашны асуудлыг хэрхэн гаргаж тавин, шийдвэрлэдэг байвал зохистойн талаарх өөрсдийн бодол, саналыг илэрхийлэхэд ийм байна.

SUMMARY

The aim of this article is to express theoretical position that bears down valuation of religion in Mongolia that grounded on monist methodology before 1990. We believe that implementation of this aim would be exchange of opinion with people those who are working on same field. In the beginning part of this article, we considered conceptual background and social situation of negative valuation of religion in Mongolia during the socialist time.

In Mongolia since 1990, democratic reform has been challenged in all sphere of life in Mongolia. In this case, we consider that theoretical research that reveals new approaches and phenomena in the work of researchers who study religion in point of view of philosophy. For example, methodology of defining concept of religion, transcendental power, understanding of religion as opium Marx said and use of agnosticism.

НОМ ЗҮЙ

Монгол Ардын Хувьсгалт Намын программ. УБ., 1966

Е.П. Блаватская., Тайная доктрина. Том 1, М.-Харьков, 2004.


Ф. Энгельс. Дюрингийн эсрэг, УБ., 1978

Бунийхны Ц. Гомбосүрэн. Христос шашины орчин үе дэх философичиглэлүүд. УБ., 2001

Бунийхны Ц. Гомбосүрэн. Философи. Сурах бичиг. УБ., 2008

Мел Томпсон. Философия религии. Пер.с англ. Ю.Бушевой. М., 2001

Самдангийн Цэдэндамба. Монгол улс дахь шашины нөхцөл байдал (XX-XXI зууны зааг үе). УБ., 2003



4244

Балдоогийн Дагзмаа. И.Кантын болон экзистенциалист философи дахьхүний оршихуйн болон ёс суртахууны үйл ажиллагааны утга учрын асуудал (диссертацийн ажил). УБ., 2000, 1-р бүлэг 2-р зүйл, 2-р бүлэг 1-р зүйл

The Cambridge Dictionary of Philosophy. General Editor Robert Audi. 1995

<http://www.philosophyofreligion.info>

<http://www.interleaves.org/~rteeter/phil.html>

<http://www.philosophy-religion.org/>